

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 06 дугаар
сарын 25-ны өдөр

Дорноговь аймаг

**Орон нутгийн 2025 оны төсвийн орлогын бүрдүүлэлтийн
талаар авах зарим арга хэмжээний тухай**

Тус хэлтсийн 2025 оны хагас жилийн мэдээний өссөн дүнгээр орон нутгийн төсөвт 995,596,594 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлж буй орлогын 4 хувийг тэмдэгтийн хураамжийн орлого, 95.3 хувийг үл хөдлөх эд хөрөнгийн 2 хувь борлуулсны орлого, 0.7 хувийг Зөрчлийн тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдэж буй торгуулийн орлого тус тус бүрдүүлсэн байна.

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд буюу 2025 оны хагас жилийн мэдээний өссөн дүнгээр үндэсний энгийн гадаад паспорт 3574, иргэний цахим үнэмлэх 1742, шилжилт хөдөлгөөний бүртгэл 1129 бүртгэлийг хийж 17,870,000 төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд буюу 2025 оны хагас жилийн мэдээний өссөн дүнгээр шинээр байгуулсан хуулийн этгээдийн бүртгэл-189, Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл-215, Хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газар шинээр бүртгүүлсэн-16, шашны байгууллагын өөрчлөлт-2 бүртгэл хийж 10.866.000 төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд буюу 2025 оны хагас жилийн мэдээний өссөн дүнгээр эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхээ бүртгүүлэхээр үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл 245, худалдах, худалдан авах гэрээгээр өмчлөх эрх шилжсэн бүртгэлийн 502 мэдүүлгийг хүлээн авч хугацаанд нь хянан шийдвэрлэсэн. Эдгээр үйлчилгээг хийснээр 11,571,530 төгрөгийн тэмдэгтийн хураамж, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 2 хувь болох татвар 947,859,064 төгрөгийг орон нутгийн дансанд тус тус төвлөрүүлсэн.

Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

Тайлант хугацаанд буюу 2025 оны хагас жилийн байдлаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 163 иргэн, 8 хуулийн этгээдэд холбогдох 171 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 7.430.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС